



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/220

Мөрөн сум

Явган хүний замын ажлыг ашиглалтад  
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.5, 28 дугаар зүйлийн 28.1, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 7-р хорооны явган хүний замын ажлыг ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Н.Буян-Өлзий (Мэргэжлийн хяналтын газрын Авто замын хяналтын улсын байцаагч)

Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Л.Бямбасүрэн (Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч)

Э.Наранчимэг (Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төвийн хяналтын инженер)

Ц.Оюун-Эрдэнэ (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

С.Баярхүү ("ОСБИМО" ХХК-ийн Захирал)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Д.Лхагвасүрэн ("Хөвсгөл зам" ХХК-ийн Захирал)

С.Баярхүү ("Хөвсгөл зам" ХХК-ийн Ерөнхий инженер)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Д.Идэрмөнх (Мөрөн сумын Засаг даргын орлогч)

Ш.Баасанпүрэв (Мөрөн сумын Архитектор, дэд бүтэц, нийтийн дээвэр хариуцсан мэргэжилтэн)

Д.Билгүүн ("Хот тохижилт үйлчилгээний төв" ХХК-ийн Зам хариуцсан ажилтан)

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Баасанжав (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)


2. Явган хүний замын ажлыг ашиглалтад оруулах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн дотор танилцуулахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Авто зам засварын ажлыг ашиглалтад оруулсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Баасанжав) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй зам засварын ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР